

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.07.28

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- S&P 500 индекс болон Nasdaq Composite индекс хоёр долоо хоног дараалан дээд ханшаа шинэчиллээ.
- Хувьцааны зах зээлд эерэг нөлөө үзүүлсэн гол хүчин зүйлийн нэг нь АНУ Япон, Индонез, Филиппин улсуудтай худалдааны хэлэлцээр байгуулсан талаарх мэдээнүүд байв.
- Alphabet (Google) лхагва гарагт таамаглалыг давсан үзүүлэлттэй тайлан гаргаж, хувьцааны үнэ 4.38%-иар өссөн байна.
- Нийт нийлмэл PMI гарцын индекс 1.7 нэгжээр нэмэгдэж 54.6-д хүрсэн нь он гарсаар үзүүлсэн хамгийн өндөр үзүүлэлт болжээ.
- АНУ-ын Сангийн сайд Скотт Бессент энэ долоо хоногт Шведийн Стокгольм хотод Хятадын албаны хүмүүстэй гурван дахь шатны хэлэлцээр хийхээр төлөвлөж байгаа юм.
- СК Hutchison болон түүний түншүүд зохицуулалтын зөвшөөрөл авахын тулд хөрөнгө оруулагчийн бүтцэд өөрчлөлт хийх, Хятадын стратегийн хөрөнгө оруулагчийг тэнцвэртэй оролцуулах арга зам хайж буй бололтой.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.07.21-07.27

ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ҮР ДҮНД ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ.

Өнгөрсөн долоо хоногт хувьцааны зах зээл өсөлттэй байсан бөгөөд S&P 500 индекс болон Nasdaq Composite индекс хоёр долоо хоног дараалан дээд ханшаа шинэчиллээ. Dow Jones аж үйлдвэрийн дундаж индекс 1.26%-иар өссөн бол S&P MidCap 400 болон Russell 2000 индексүүд хоёулаа 0.9%-иас дээш өсөлт үзүүлэв. Хол зөрүүтэй биш ч гэлээ өнгөрсөн долоо хоногт value хувьцаанууд growth хувьцаанаас илүү сайн гүйцэтгэл үзүүлсэн байна.

Хувьцааны зах зээлд эерэг нөлөө үзүүлсэн гол хүчин зүйлийн нэг нь АНУ Япон, Индонез, Филиппин улсуудтай худалдааны хэлэлцээр байгуулсан талаарх мэдээнүүд байв. Мөн АНУ болон Европын Холбоо (ЕХ) наймдугаар сарын 1-нээс өмнө тохиролцоонд хүрэх чиглэлд ахицтай ажиллаж буй талаар мэдээлэл гарсан нь зах зээлд итгэл төрүүлсэн байна. Ерөнхийлөгч Дональд Трамп хэрвээ хэлэлцээр байгуулагдахгүй бол Европын бараанд 30%-ийн тариф тогтоохоо мэдэгдсэн.

Мөн олон компанийн тайлан гарсан бөгөөд үүнд “гайхамшигт долоон” хэмээн нэрлэгддэг технологийн компаниудын хоёр багтсан юм. Тайлангууд холимог хүлээлт дагуулсан. Alphabet (Google) лхагва гарагт таамаглалыг давсан үзүүлэлттэй тайлан гаргаж, хувьцааны үнэ 4.38%-иар өссөн байна. Тус компанийн хиймэл оюун ухааны талаарх мэдэгдэл нь AI технологид суурилсан бусад хувьцаанд ч эерэг нөлөө үзүүлжээ. Харин Tesla-ийн тайлан хүлээлтэд хүрээгүй тул тус компанийн хувьцаа долоо хоногийн дүнгээр 4.12%-иар унасан байна.

Долоо хоногийн хамгийн онцлох мэдээлэл нь S&P Global-ийн худалдан авагч менежерүүдийн индекс (PMI)-ийн долоодугаар сарын тайлан байлаа. Тус тайланд дурдсанаар, гуравдугаар улирал эхлэх үед АНУ-ын бизнесийн идэвхжил эрчимжсэн нь ажиглагдаж байгаа бөгөөд нийт нийлмэл PMI гарцын индекс 1.7 нэгжээр нэмэгдэж 54.6-д хүрсэн нь он гарсаар үзүүлсэн хамгийн өндөр үзүүлэлт болжээ. (50-иас дээш үзүүлэлт нь өсөлтийг илэрхийлдэг). Энэхүү өсөлт нь зөвхөн үйлчилгээний салбарт гарсан өсөлтөөр бий болсон бөгөөд үйлчилгээний PMI 6-р сарын 52.9-өөс 7-р сард 55.2 болж өссөн байна. Харин үйлдвэрлэлийн PMI 52.9-өөс 49.5 болж унасан нь өнгөрсөн 12-р сараас хойших хамгийн доод түвшин юм. Энэ нь аж үйлдвэр суларч байгааг харуулж байна. Гэсэн ч энэ өсөлт тогтвортой үргэлжлэх эсэх нь эргэлзээтэй. Өсөлт маш жигд бус, зөвхөн үйлчилгээний салбараас хамааралтай байгаад санаа зовж байна.

Ипотекийн өндөр хүүгийн улмаас орон сууцны зах зээл сул хэвээр байна. Лхагва гарагт АНУ-ын Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдын үндэсний холбоо (National Association of Realtors) зургаадугаар сард орон сууцны хоёрдогч зах зээлийн борлуулалт өмнөх сараас 2.7%-иар буурч, улирлын нөлөөг харгалзсан жилийн хандлагаар 3.93 сая нэгжид хүрсэн талаар мэдээлэв. Мөн худалдаалагдсан орон сууцны дундаж үнэ 435,300 ам.доллар болж түүхэн дээд түвшинд хүрсэн байна. Тайланд тэмдэглэснээр: “Ипотекийн өндөр хүү нь орон сууцны борлуулалтыг эргэлтийн доод түвшинд удаан хугацаанд тогтоон барьж байна. Олон жилийн турш орон сууцны хангамж хангалтгүй байсан нь одоогийн үнийн дээд түвшинг бий болгож байна.”



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.07.21 – 07.27

ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ.

Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл АНУ-тай тарифын одоогийн нөхцөлийг сунгах найдлагаар өсөв. АНУ, Хятад хоёрын ээлжит худалдааны хэлэлцээ болохоос өмнө тарифын зогсолт сунгагдах магадлал нэмэгдсэнтэй холбоотойгоор Хятадын хөрөнгийн зах зээл өсөлттэй байлаа. CSI 300 индекс 1.69%-иар, Шанхайн нийлмэл индекс 1.67%-иар тус тус өссөн. Харин Хонг Конгийн Hang Seng индекс 2.27%-иар өслөө.

АНУ-ын Сангийн сайд Скотт Бессент энэ долоо хоногт Шведийн Стокгольм хотод Хятадын албаны хүмүүстэй гурван дахь шатны хэлэлцээр хийхээр төлөвлөж байгаа юм. Энэ хэлэлцээр нь наймдугаар сард дуусах буюу одоо хэрэгжиж буй худалдааны хэлэлцээрийг сунгах зорилготой.

СК Hutchison компани даваа гарагт мэдэгдэл хийж, 22.8 тэрбум ам.долларын далайн боомтын бизнесээ худалдах хэлэлцээрийн хүрээнд BlackRock-ын ахалсан концерциумд Хятадын стратегийн хөрөнгө оруулагчийг (мэдээлснээр төрийн өмчит China COSCO Shipping Corp) нэгдэхийг хүсэж буйгаа илэрхийлжээ. Хонг Конгод төвтэй энэ олон улсын конгломерат хэлэлцээрт зохицуулалтын зөвшөөрөл авахын тулд концерциумын бүрэлдэхүүн болон хэлцлийн бүтцэд өөрчлөлт оруулах шаардлагатай болох бөгөөд энэ зорилгод хүрэх хүртэл шаардлагатай хугацааг хангалттай өгнө гэжээ.

Энэхүү хэлэлцээрийн 145 хоногийн онцгой эрхийн хугацаа Ням гарагт дууссан байна. СК Hutchison-ийн Хонг Конгийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны ханш Даваа гарагийн арилжааны эхэнд ойролцоогоор 1%-иар өсөх төлөвтэй байна. Энэхүү хэлцэл нь 23 улс дахь 43 боомтыг хамрах бөгөөд үүнд Атлант, Номхон далайг холбодог Панамын сувгийн дэргэдэх хоёр боомт багтжээ.

Геополитикийн өрнөлийн хувьд АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп анх уг борлуулалтыг Панамын сувгийг эргүүлэн авлаа" хэмээн магтаж байсан. Түүний засаг өмнө нь зарим боомтыг Хятадын мэдэлд байна хэмээн үзэж, тэдгээрийг "цэвэрлэхийг" шаардсан. АНУ-ын хөрөнгө оруулалтын компани BlackRock тайлбар өгөхөөс татгалзсан бол COSCO, Италийн MSC болон Цагаан ордон одоогоор сэтгүүлчдийн асуултад хариулаагүй байна.

Харин Хятад улс энэхүү хэлцлийг өөрийн ашиг сонирхолд заналхийлж байна хэмээн үзэж байгаа бөгөөд уг концерциумыг АНУ-ын нөлөөллийг бүс нутагт нэмэгдүүлнэ хэмээн болгоомжилж байна. Хятадын төрийн мэдээллийн хэрэгслүүд хэлцлийг хурцаар шүүмжилж, дараах байр суурийг илэрхийлжээ. Хятадын хувьд уг боомтууд үндэсний стратегийн чухал ашиг сонирхолтой шууд холбоотой. Тиймээс тэдгээрийг худалдах нь эх орноос урвасан үйлдэл болно.

Дүгнэлт:

- Хятадын тал энэхүү хэлцлийг эдийн засгийн аюулгүй байдал, нөлөөллийн хүрээний хүрээнд өндөр ач холбогдолтой гэж үзэж байна.
- СК Hutchison болон түүний түншүүд зохицуулалтын зөвшөөрөл авахын тулд хөрөнгө оруулагчийн бүтцэд өөрчлөлт хийх, Хятадын стратегийн хөрөнгө оруулагчийг тэнцвэртэй оролцуулах арга зам хайж буй бололтой.
- АНУ, Хятад хоёрын геополитикийн өрсөлдөөн энэ хэлэлцээрийн цаана шууд нөлөө үзүүлж байна.

